

**ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА  
(2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар)**

2021 оны 06 дугаар сарын 18

Улаанбаатар хот

**НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО**

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын чиг үүрэг, үйл ажиллагааны дагуу бүртгэл-хяналтад авсан хууль тогтоомж тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах, байгууллагын үйл ажиллагааны хэрэгжилтийг цаг хугацаанд нь зохион байгуулах, үр дүнг дээшлүүлэх, удирдлагыг мэдээллээр хангахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

**ХОЁР. ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ**

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.3-т заасан аргачлалыг баримтлан тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг 2021 оны эхний хагас жилийн байдлаар нэгтгэн дүгнэж, үнэлгээ хийсэн.

Үүнд: “90-100 хувийн үнэлгээтэй буюу “Бүрэн хэрэгжсэн”-100 хувь, “50-89 хувийн үнэлгээтэй буюу “Хэрэгжих шатанд”-70 хувь, “10-49 хувийн үнэлгээтэй буюу “Хэрэгжилт хангалтгүй”-30 хувь, “0-9 хувийн үнэлгээтэй буюу “Хэрэгжээгүй”-0 хувь, “Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” гэсэн аргачлалаар үнэллээ.

**ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН**

2021 оны эхний хагас жилийн байдлаар Монгол Улсын хууль, Засгийн газрын тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамжаар өгсөн 27 шийдвэрийн 134 заалт тус газарт “Хэрэгжих шатанд” буюу 70 хувийн биелэлттэй байна. Үүнд:

1. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн холбогдох 14 заалтаас “Бүрэн хэрэгжсэн” буюу 100% хэрэгжсэн 13, “Хэрэгжих шатанд” буюу 70% хэрэгжсэн 1 заалт, Төрийн албаны тухай хуулийн холбогдох 1 заалт “Хэрэгжих шатанд” буюу 70% хэрэгжсэн байна. Эдгээрийн дунджаар хууль тогтоомжийн биелэлтийн дүн 96 хувьтай байна.
2. Төрийн албаны сахилга, дэг журмыг чангатгах тухай Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 258 дугаар тогтоолын 9 заалтаас “Бүрэн хэрэгжсэн” буюу 100% хэрэгжсэн 7, “Хэрэгжих шатанд” буюу 70% хэрэгжсэн 2 заалт, 2020 оны 21 дүгээр тогтоолын 1 заалт “Бүрэн хэрэгжсэн” буюу 100% хэрэгжсэн, 2021 оны 15 дугаар тогтоолын 1 заалт “Хэрэгжилт хангалтгүй” 30% хэрэгжсэн. Эдгээрийн дунджаар тогтоол, шийдвэрийн биелэлтийн дүн 88.1 хувьтай байна.
3. Нийслэлийн Засаг даргын худалдан авах ажиллагааны эрх шилжүүлэх тухай 22 захирамжийн 108 заалтаас “Бүрэн хэрэгжсэн” буюу 100% хэрэгжсэн 20, “Хэрэгжих шатанд” буюу 70% хэрэгжсэн 15, “Хэрэгжилт хангалтгүй” 30%, хэрэгжсэн 34%, “Хэрэгжээгүй” 0% биелсэн 2, Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй 37 ажил тус тус байна. Эдгээрийн дунджаар захирамжийн биелэлтийн дүн 57,3 хувьтай байна.

Тогтоол шийдвэр, захирамжлалын баримт бичиг, хэрэгжилтийн хувиар

Хүснэгт 1

№	Баримт бичгийн нэр	Шийдвэрийн	Нийт заалт	Үнэлгээний хувь				Хэрэгжилтийг тооцох хугацаа	Биелэлтийн дундаж хувь	Үнэлгээ
				100%	70%	30%	0%			
1	Монгол Улсын хууль	2	15	13	2			96 %	"Бүрэн хэрэгжсэн" буюу 100%	
2	Засгийн газрын тогтоол	3	11	8	2	1		88.1 %	"Хэрэгжих шатанд" буюу 70%	
3	Нийслэлийн Засаг даргын захирамж /ХАА холбоотой/	22	108	20	15	34	2	37	57.3 %	"Хэрэгжих шатанд" буюу 70%
<b>Нийт</b>		27	134	41	19	35	2	37	80.4 %	"Хэрэгжих шатанд" буюу 70%

2 Худалдан авах ажиллагааны явц:

Хүснэгт 2

Худалдан авах ажиллагааны явц		Захирамжаар эрх шилжин ирсэн төсөл, арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн үнэлгээ
<b>Тендер зарлагдсан</b>			
1	Гэрээ хийгдсэн	4	100% "Бүрэн хэрэгжсэн"
2	Гэрээ байгуулах эрх олгосон	16	
3	Үнэлгээ хийж байгаа	15	70% "Хэрэгжих шатанд"
4	Тендерийн материал хүлээн авч байгаа	34	30% "Хэрэгжилт хангалтгүй"
<b>Тендерийн бэлтгэл шатанд</b>			
5	Тендерийн баримт бичиг боловсруулж байгаа	2	0% "Хэрэгжээгүй"
6	Зураг төсөв ажлын даалгавар хүлээгдэж байгаа ажил	37	"Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй"
<b>ДУНДАЖ ХУВЬ</b>		108	57,3 хувь

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, САНАЛ

4.1 Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 4 дүгээр зүйл, Засгийн газрын 2013 оны 411 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журам” –аар хүлээсэн үүргийн хүрээнд холбогдох мэдээллийг “тогтмол шинэчлэх”, “тухай бүр шинэчлэх”, “ойлгомжтой байдлаар байрлуулах”-д тус тус анхаарч дараах мэдээллийг цахим хуудаст байршуулах шаардлагатай байна. Үүнд:

- Байгууллагын цахим хуудаст Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэлийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнгийн талаарх мэдээлэл,
- Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал болон уг ажилтны ажиллах журмыг нүүр хуудаст харагдах байдлаар байршуулах.
- Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журам
- Тухайн байгууллагын удирдлагаас гаргасан тушаал шийдвэрийн ил тод байдлыг хангах. Захиргааны шийдвэрийн нэгдсэн сан <http://ublegal.mn/> системийн линкийг байршуулсан боловч энэ онд тус газарт батлагдсан А тушаалыг тухайн системд нийтлээгүй байна.

4.2 Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухайн жилийн төлөвлөгөөний биелэлтийг цаг хугацаанд нь зохион байгуулж ажиллах.

4.3 Худалдан авах ажиллагаа хэрэгжээгүй үнэлгээтэй байгаа 2 төсөл, арга хэмжээ нь Тендерийн баримт бичиг боловсруулах шатанд байгаа бөгөөд 2 удаа сонгон шалгаруулалтыг зарлаад дахин зарлахаар 1 ажил, 2021 оны 06 дугаар сарын 07-ны өдөр тус газарт зураг, төсөв ажлын даалгавар ирсэн 1 ажил тус тус байна.

(1. Мал эмнэлгийн хүрээлэнгийн засвар /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/,

2.52 дугаар сургуулийн барилгын дээвэр, гал тогоо, шалныг их засвар /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/ )

Зураг төсөв, ажлын даалгавар ирүүлээгүй 37 төсөл, арга хэмжээний хувьд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3-т дахь хэсэгт заасан “Төсвийн ерөнхийлөн захирагч улсын төсөв батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор энэ хуулийн 45.4-т заасан худалдан авах бараа, ажил, үйлчилгээний захиалгыг төсөл, арга хэмжээ бүрийн техникийн тодорхойлолт, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, ажлын даалгавар болон бусад шаардлагатай мэдээллийн хамт худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагад хүргүүлнэ” гэж заасны дагуу захиалагч байгууллагаас хамааран хүлээгдэж байгаа тул “Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” ангилалд бүртгэж байна.

ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ТАНИЛЦСАН:  
ОРЛОГЧ ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Г.ЭНХТАЙВАН

Г.СОДБАЯР

ХЯНАСАН:  
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.ДӨЛГӨӨН

ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН:  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



Д.ЖАРГАЛМАА

**НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР  
ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ДҮН  
/2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар /**

2021 оны 03 дугаар сарын 18

		Нийт	Монгол Улсын хууль	Засгийн газрын тогтоол	Нийслэлийн Засаг даргын захирамж /ХАА холбоотой/
Нийт шийдвэрийн тоо		27	2	3	22
Нийт заалтын тоо		134	15	11	108
Бүрэн хэрэгжсэн	100	41	13	8	20
Хэрэгжиж байгаа	70	19	2	2	15
Хэрэгжилт хангалтгүй	10	-	-	-	-
Эрчимжүүлэх шаардлагатай	30	35	-	1	34
Хэрэгжилтийн хугацаа тооцох болоогүй	-	37	-	-	37
Хэрэгжээгүй	0	2	-	-	-
Үүнээс:	Зохион байгуулалтаас шалтгаалсан	0	-	-	-
	Хөрөнгө дутагдсанаас шалтгаалсан	0	-	-	-
Хяналтаас хасуулах саналтай		-	-	-	-
Гүйцэтгэлийн хувь		80.4%	96%	88.1%	57.3%
Үнэлгээний хувь		70%	100%	70%	70%